

42



МОНГОЛ УЛС
ДОРНОД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2022 оны 09 сарын 30 өдөр

Дугаар АСН

Чойбалсан

Г Тусгай зөвшөөрөл олгох тухай Г

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1, Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1.1, 10.1.3, 16 дугаар зүйлийн 16.2.2, Эрүүл мэндийн тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.1, 19.2, 19.3, 19.3.5, 19.18 дахь заалт, Эрүүл мэндийн Сайдын 2021 оны 400 дугаар тушаал, "Эрүүл мэндийн чиглэлээр мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийн комисс"-ын 2022 оны хоёрдугаар хуралдааны шийдвэрийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. "Цацрал тун фарм" ХХК-ийн "Цацрал тун фарм" /2 дугаар зэрэглэл/ эмийн санд үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг 3 жилийн хугацаагаар олгож, хавсралтаар баталсугай.


2. Хуулиар хүлээсэн үүргээ бүрэн биелүүлж, эрүүл мэндийн тусламж үйлчилгээг чанартай үзүүлэхийг "Цацрал тун фарм" ХХК-ийн захиралд үүрэг болгосугай.

3. Тусгай зөвшөөрөл эзэмшигч аж ахуйн нэгжийн хууль тогтоомжийн дагуу үйл ажиллагаа явуулж буй эсэхэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Эрүүл мэндийн газар, Эрүүл мэндийн чиглэлээр мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийн комиссын ажлын алба (Ч.Оюунаа), Мэргэжлийн хяналтын газар (Д.Мөнхтуяа)-т тус тус даалгасугай.

4. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын тамгын газрын Нийгмийн бодлогын хэлтэс (Э.Эрдэнэбилэг)-т үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА

М.БАДАМСҮРЭН



Аймгийн Засаг даргын 2022 оны
2 дугаар сарын 2 - ны өдрийн
2022 дугаар захирамжийн хавсралт



ТУСГАЙ ЗӨВШӨӨРӨЛ ОЛГОХ ЭРҮҮЛ
МЭНДИЙН БАЙГУУЛЛАГА

№	Хуулийн этгээдийн нэр	Оноосон нэр	Байршил	Үйл ажиллагааны чиглэл	Олгосон хугацаа	Хүчинтэй хугацаа	
						Эхлэх	Дуусах
1	"Цацрал тун фарм" ХХК	"Цацрал тун фарм" эмийн сан	Хэрлэн сум 11-р баг содномдаржа а 2, 219/1, 20	2 дугаар зэрэглэлийн эмийн сан	3 жил	2022.09. 30	2025.09. 30